



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 07 сарын 07 өдөр

Дугаар А/478

Булган сум

Газар эзэмших эрхийн гэрчилгээний
хугацаа сунгах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, 37 дугаар зүйлийн 37.2 дахь заалт, Засгийн газрын 2025 оны 121 дүгээр тогтоолоор батлагдсан “Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам”, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 3 дугаар сарын 29-ний өдрийн хуралдааны IX/19 дүгээр тогтоолоор баталсан “Булган сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”-г тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Булган сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй эзэмшиж буй газрын зориулалт нь нийцэж байгаа хавсралтад заасан газар эзэмшигч 2 иргэн, 2 хуулийн этгээдийн 4 нэгж талбарын газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацааг 15 жилээр сунгасугай.

2. Хавсралтад заасан 2 иргэн, 2 хуулийн этгээдтэй газар эзэмшүүлэх гэрээг шинэчлэн байгуулж, гэрчилгээжүүлэн газар эзэмшилтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т даалгасугай.

3. Газрыг зориулалтын дагуу зүй зохистой эзэмшихийг энэхүү захирамжийн хавсралтад тусгасан 2 иргэн, 2 хуулийн этгээдэд үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР



Аймгийн Засаг даргын 2025 оны
07 дугаар сарын 07-ны/ний өдрийн
А.Н.А. дугаар захирамжийн хавсралт

ГАЗАР ЭЗЭМШИХ ЭРХИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ ХУГАЦАА СУНГАЖ БАЙГАА
ИРГЭДИЙН НЭРС, ГАЗРЫН ХЭМЖЭЭ, БАЙРШИЛ

д/д	Иргэн, хуулийн этгээдийн овог нэр		Регистрийн дугаар	Газрын зориулалт	Баг	Гудамж	Хаалганы дугаар	Газрын хэмжээ /м.кв/	Нэгж талбарын дугаар
1	2		3	4	5	6	7	8	9
1	Цэрэнням	Булганчимэг	ГЮ75100400	Зочид буудлын цогцолбор, олон нийтийн газар	5	Анхдагчдын өргөн чөлөө	112а	707	6308003366
2	Жамьянжав	Наранцогт	ХН64050813	Худалдаа үйлчилгээ	5	Хатанбаатар С.Магсаржав-1	111а	781	6308005534
3	"Элбэг Эд" ХХК		4398009	Худалдаа үйлчилгээ	5	Хатанбаатар С.Магсаржав-2	238	279	6308008135
4	"Гантай" ХХК		2007371	Үйлдвэрлэл	5	Гурилын үйлдвэр-2	201	5956	6308008907